ТӨРИЙН АУДИТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК-ИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД:СНАГ-2025/5/НА-СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б. Долгорсүрэн
Утас: 260512 Цахим хаяг: dolgorsuren.b@audit.gov.mn
Аудитор: Г. Оюунтөгөлдөр
Утас: 261740 Цахим хаяг: oyuntuguldur.g@audit.gov.mn
“Мэдээлэл Аудит” ХХК-ийн Захирал Д.Товуудорж
Утас:70159511, 99049511 Цахим хаяг: medeelelaudit@gmail.com

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ 4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН 7
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 7
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан 8
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан 9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 12
3.1 Компани/ТӨХХК/, түүний үйл ажиллагаа 12
3.2 Компанийн гадаад, дотоод орчин 12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт 13
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл 15
4. АУДИТЫН ТАЙЛАН 16
4.1 Ерөнхий зүйл 16
4.2 Материаллаг байдал 16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 18
4.5.1 Завсрын аудитын талаар 18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн 18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 19
5.2 Албан шаардлага 19
5.3 Зөвлөмж 20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ 22
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл 23
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 23
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
ББӨ	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг
ДЭХ	Дулааны эрчим хүч
НББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТЗБАХ	Техник зохион байгуулалтын арга хэмжээ
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УБДС	Улаанбаатар дулааны сүлжээ
УБТЗ ХНН	Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэг
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЦДҮС	Цахилгаан түгээх үндэсний сүлжээ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨХХК-ИЙН ЗАХИРАЛ Д. БЯМБАСҮРЭН
ТАНАА

2025.03.17 № 07/1035
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, заавр-ын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй дараах алдаа, зөрчил нь тогтоосон 542.5 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Байгууллагаас авах 392.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй;
- Майнримек ХХК, Блейк стар альфа ХХК, Огмент ХХК, Визлис визард ХХК, Энхансмент ХХК-тай нэвтрүүлэг, контентын үйлчилгээ авах гэрээг байгуулж, өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 99.8 сая төгрөгийн үйлчилгээг санхүүжүүлсэн;
- Тосны ус болон тосны зунгааралт тодорхойлох 21.6 сая төгрөгийн төгрөгийн ижил төрлийн багажийг шууд худалдан авалт хийх зорилгоор баталсан өртөгийг хуваж, нэг байгууллагаас худалдан авсан;
- Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан 890 нэр төрлийн үндсэн хөрөнгүүд байгаа зэрэг зөрчлүүд бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Z:\Yawsan_Bichig\2025\0317 SNAG-42.Docx

1525071168

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т "Төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хуваж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэн зөв байдал, үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Эрчим хүчний хөгжлийн төв ТӨХХК-ийн санхүүгийн тайланд бүртгэлтэй байсан, компанийг өөрчлөн байгуулах шийдвэрээр шилжиж ирсэн Эгийн голын усан цахилгаан станц барих төслийн хүрээнд 1992 онд үүссэн 1152-MON(SF) дугаар гэрээгээр гүйцэтгүүлсэн 3,731.1 сая төгрөгийн ТЭЗҮ, зураг төслийн судалгааны өр төлбөр бүртгэлтэй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Чойбалсангийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх төслийн ажлын зураг төсөл боловсруулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, барилга угсралтын, Хөгжлийн банкны санхүүжилтээр Улаанбаатар хотын зүүн бүсийн дулааны хэрэглээний өсөлтийг хангах төслийн хүрээнд Амгалан дулааны станцыг 116 МВт-ын зуухаар өргөтгөх, хувийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн Бөөрөлжүүтийн цахилгаан станцын 1-р блокийн 150МВт-ын барилга угсралтын ажлыг ажлыг Улсын комисс хүлээн авч, байнгын ашиглалтад өгсөн.

Завхан аймгийн Тосонцэнгэл суманд баригдаж буй 30МВт-ын, Сэлэнгэ аймагт баригдаж буй 70МВт-ын дулааны цахилгаан станцын барилга угсралтын ажилд хяналт тавин ажиллаж байна.

Бусад асуудал

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулийн хавсралтаар Эрчим хүчний сайдын төсвийн багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 51 төсөл, арга хэмжээний 99 барилга угсралтын ажлаас 37 нь ашиглалтад орсон, Мянганы сорилын сангийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн 9 багц ажилд техникийн хяналт хэрэгжүүлэн хүлээлгэн өгсөн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АТА9693 109
9023030583

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1.1.01	Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	4,813,676,309.33	8,154,996,886.54
1.1.02	Дансны авлага	1,116,704,675.65	1,119,715,490.60
1.1.04	Бусад авлага	1,522,313.78	9,576,792.56
1.1.06	Бараа материал	382,723,355.76	386,997,410.32
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	47,779,795.15	19,560,050.16
1.1.11	**Эргэлтийн хөрөнгийн дүн**	**6,362,406,449.67**	**9,690,846,630.18**
1.2.01	Үндсэн хөрөнгө	8,484,242,674.55	8,503,996,863.07
1.2.02	Биет бус хөрөнгө	62,719,758.55	91,372,937.91
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө	12,884,359,100.00	9,128,327,100.00
1.2.10	**Эргэлтийн бус хөрөнгийн дүн**	**21,431,321,533.10**	**17,723,696,900.98**
1.3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН**	**27,793,727,982.77**	**27,414,543,531.16**
2.1.1.01	Дансны өглөг	3,972,696,652.71	410,802,174.92
2.1.1.02	Цалингийн өглөг	-	-
2.1.1.03	Татварын өр	711,237,155.03	1,166,179,255.83
2.1.1.04	НДШ-ийн өглөг	-	9,082,114.80
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	1,432,005,578.01	2,682,586,941.43
2.1.1.13	**Богино хугацаат өр төлбөрийн дүн**	**6,115,939,385.75**	**4,268,650,486.98**
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	3,731,110,140.00	3,731,110,140.00
2.1.2.06	**Урт хугацаат өр төлбөрийн дүн**	**3,731,110,140.00**	**3,731,110,140.00**
2.2	**Өр төлбөрийн нийт дүн**	**9,847,049,525.75**	**7,999,760,626.98**
2.3.01	Өмч: - төрийн	3,300,991,177.74	3,300,991,177.74
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,019,474,302.61	3,019,474,302.61
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	14,279,770,721.57	10,523,738,721.57
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(2,653,557,744.89)	2,570,578,702.26
2.3.11	Эздийн өмчийн дүн	17,946,678,457.03	19,414,782,904.18
2.4	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН**	**27,793,727,982.77**	**27,414,543,531.16**

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	7,470,552,078.12	9,410,677,866.02
2	Борлуулалтын өртөг	42,700,225.89	38,440,782.66
3	**Нийт ашиг(алдагдал)**	**7,427,851,852.23**	**9,372,237,083.36**
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	112,017,267.63	273,516,284.28
8	Бусад орлого		3,458,523,887.97
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	7,168,947,212.13	7,325,611,764.50
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	30,803,382.27	0.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(5,838,246.54)	(4,460,134.96)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0	0
18	**Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)**	**334,280,278.92**	**5,774,205,354.15**
19	Орлогын татварын зардал	33,428,027.89	550,068,906.99
20	**Татварын дараах ашиг (алдагдал)**	**300,852,251.03**	**5,224,136,447.16**
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)		
22	**Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)**	**300,852,251.03**	**5,224,136,447.16**
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	**Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)**		

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАГДМАЛ ТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 01-р сарын 01-ны үлдэгдэл	**3,300,991,177.74**	**3,019,474,302.61**	**14,027,740,234.70**	**(2,954,409,995.93)**	**17,393,795,719.12**
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө,алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл	**3,300,991,177.74**	**3,019,474,302.61**	**14,027,740,234.70**	**(2,954,409,995.93)**	**17,393,795,719.12**
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				300,852,251.04	300,852,251.04
Өмчид гарсан өөрчлөлт			252,030,486.87		252,030,486.87
2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	**3,300,991,177.74**	**3,019,474,302.61**	**14,279,770,721.57**	**(2,653,557,744.89)**	**17,946,678,457.03**
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө,алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл	**3,300,991,177.74**	**3,019,474,302.61**	**14,531,801,208.44**	**(2,653,557,744.89)**	**17,946,678,457.03**
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				5,224,136,447.16	5,224,136,447.16
Өмчид гарсан өөрчлөлт			(3,756,032,000.00)		(3,756,032,000.00)
2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	**3,300,991,177.74**	**3,019,474,302.61**	**10,775,769,208.44**	**2,570,578,702.27**	**19,414,782,904.18**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	**Мөнгөн орлогын дүн (+)**	**9,235,263,246.86**	**12,073,446,657.35**
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	9,174,703,344.88	11,987,238,804.35
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	60,559,901.98	86,207,853.00
1.2	**Мөнгөн зарлагын дүн (-)**	**5,588,934,166.78**	**8,341,508,722.47**
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,965,875,892.32	2,887,753,022.91
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	809,340,818.68	928,108,887.35
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	258,753,097.10	177,736,178.56
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	55,268,043.84	62,031,756.79
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	59,128,700.00	77,451,250.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	891,408.46	26,509,748.31
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	365,522,383.26	1,053,191,351.03
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	27,568,992.00	56,116,536.73
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,046,584,831.12	3,072,609,990.79
1.3	**Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**3,646,329,080.08**	**3,731,937,934.88**
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	**Мөнгөн орлогын дүн (+)**	**112,017,267.63**	**265,099,617.28**
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	112,017,267.63	265,099,617.28
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	**Мөнгөн зарлагын дүн (-)**	**202,815,644.29**	**621,171,616.00**
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	193,913,609.09	553,221,616.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	8,902,035.20	67,950,000.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6	Бусад		
2.3	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**(90,798,376.66)**	**(356,071,998.72)**
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	**29,398,150.00**	**30,085,224.00**
3.2.1	Зээл,өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг	29,398,150.00	30,085,224.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(29,398,150.00)	(30,085,224.00)
	Валютын зөрүү		4,460,134.96
4	**Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**	**3,526,132,553.42**	**3,345,804,712.16**
5	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	**1,287,543,755.91**	**4,813,676,309.33**
6	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	**4,813,676,309.33**	**8,154,996,886.54**

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАГДМАЛ ТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 он		Өөрчлөлт /өссөн +, буурсан -/	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Нийт орлого	мян/төг	**7,582,569.4**	**11,736,074.6**	**9,684,194.2**	**(2,051,880.5)**	**(0.2)**
Захиалагчийн техник хяналтын орлого	мян/төг	2,549,933.3	5,377,884.0	4,803,862.5	(574,021.5)	(0.1)
Улсын төсвийн хөрөнгө оруулалт	мян/төг	2,363,504.1	2,814,655.9	2,401,931.2	(412,724.7)	(0.2)
Гадаад зээл тусламж болон хувийн хөрөнгөөр	мян/төг	186,429.2	2,563,228.1	2,401,931.2	(161,296.8)	(0.1)
Зураг төсөл магадлалын орлого	мян/төг	656,488.0	600,000.0	722,231.3	122,231.3	0.2
Сэргээгдэх эрчим хүчний орлого	мян/төг	220,720.0	2,878,730.7	1,021,195.2	(1,857,535.5)	(1.8)
Лабораторийн үйл ажиллагааны орлого	мян/төг	485,523.3	580,000.0	542,782.0	(37,218.0)	(0.1)
Тусгай зөвшөөрлийн орлого	мян/төг	1,666,931.9	980,000.0	302,672.3	(677,327.7)	(2.2)
Техникийн нөхцөлийн орлого	мян/төг	1,011,148.2	435,000.0	987,188.0	552,188.0	0.6
Сургалтын орлого	мян/төг	654,465.1	529,860.0	803,762.3	273,902.3	0.3
Түрээсийн орлого	мян/төг	100,517.7	99,600.0	95,127.3	(4,472.7)	(0.0)
Хүүгийн орлого	мян/төг	112,017.3	90,000.0	273,516.3	183,516.3	0.7
Бусад орлого /Хэвлэх цех, ҮҮА /	мян/төг	124,824.6	165,000.0	131,857.1	(33,142.9)	(0.3)
Нийт зардал	**мян/төг**	**7,248,289.1**	**11,426,608.5**	**7,369,437.0**	**(4,057,171.4)**	**(0.6)**
Татварын өмнөх ашиг (алдагдал)	мян/төг	334,280.3	309,466.2	2,314,757.1	2,005,290.9	0.9
Цэвэр ашиг (алдагдал)	мян/төг	300,852.2	278,519.6	2,110,633.0	1,832,113.5	0.9
Нийт авлага	мян/төг	1,118,227.0	1,175,928.5	1,129,292.3	(46,636.3)	(0.0)
Үүнээс: Найдваргүй	мян/төг	416,828.4	416,828.4	416,828.4	-	-
Нийт өр төлбөр	мян/төг	6,341,423.6	4,443,769.5	11,112,339.6	6,668,570.2	0.6
Богино хугацаат өр төлбөр	мян/төг	2,657,415.5	712,659.4	7,381,229.5	6,668,570.2	0.9
Урт хугацаат өр төлбөр	мян/төг	3,731,110.1	3,731,110.1	3,731,110.1	-	-
Нийт ажиллагсдын тоо	хүн	77.0	94.0	80.0	(14.0)	(0.2)
Нийт цалингийн сан	мян/төг	2,573,850.1	4,071,518.1	3,668,900.9	(402,617.2)	(0.1)
Нэг ажилтны дундаж цалин	мян/төг	2,540.5	3,609.5	3,821.8	212.3	0.1
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.0	1.0	0.8	(0.2)	(0.3)
Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	мян/төг	555,158.3	2,138,755.3	633,381.6	(1,505,373.7)	(2.4)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ТӨХХК/, түүний үйл ажиллагаа

Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн эрхэм зорилгыг "Хүн төрөлхтний дэвшилтэт ололтыг дэмжин, сэргээгдэх эрчим хүчийг сурталчлан таниулах, нэвтрүүлэх, үндэсний хэмжээнд аюулгүй ажиллагааг эрхэмлэгч эрчим хүчний салбарын тэргүүлэгч байгууллага болох"-д оршино гэж тодорхойлсон байна.

Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Эрчим хүчний салбарт улсын төсөв болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээнд захиалагчийн үүрэг гүйцэтгэж, техникийн хяналт тавих;
- Эрчим хүчний барилга байгууламжийг барих, зөвлөх үйлчилгээний ажлын зураг төсөвт магадлал, шүүмж, дүгнэлт хийх, эдгээртэй холбоотой ажлыг зохион байгуулах;
- Салбарын хэмжээнд хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэгдсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, салбарын хүний нөөцийг мэргэшүүлэх, ажлыг зохион байгуулах, мэргэшлийн зэргийг аттестатчилах арга хэмжээг зохион байгуулах;
- Цахилгаан болон дулаанжуулалтын тоноглолын найдвартай байдлыг хангах зорилгоор түлш, уур ус, тос, металл судлал , гагнуурын хяналт шинжилгээ хийх, техникийн дүгнэлт гаргах;
- Эрчим хүчний шинэ эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, зуух, даралтад сав, шугам хоолойн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход урьдчилсан дүгнэлт, үнэлгээ өгөх ажлыг зохион байгуулах;
- Эрхэлсэн асуудлаараа хууль тогтоомжийн хүрээнд гадаад, дотоодын болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, гэрээ хэлэлцээр байгуулах, мэдээлэл солилцох;
- Компани техник хяналт тавигдсан эрчим хүчний барилга байгууламжийн техникийн хяналт, зураг төсөв, холбогдох материалаар мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, сонирхогч байгууллага, иргэдэд энэ талын мэдээллээр хангах;
- Компанийн үндсэн болон хууль тогтоомжоор хориглоогүй бусад чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бизнесийн үйл ажиллагаа эрхлэх;

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК нь үйл ажиллагаандаа дараах эрх зүйн актуудыг мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- Компанийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль,
- Нийгмийн даатгалын багц хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Татварын багц хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Эрчим хүчний салбарын хамтын хэлэлцээр

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИЛЦАГЧ САНАЛ ДҮГНЭЛТ

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн ТУЗ нь тайлант онд 9 удаа хуралдаж, санхүү бүртгэл болон үйлдвэрлэлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, хөрөнгө оруулалт худалдан авалтын төлөвлөгөөний биелэлт, үүссэн хязгаарлалттай болон тулгамдсан нөхцөл байдлыг шийдвэрлэхээр 19 тогтоолыг хэлэлцэн батлсан байна.

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо 3 удаа хуралдаж, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийг мөрдөж ажиллахыг анхааруулж, 2024 оны зорилтот түвшин хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцэж, зардлыг бууруулах талаар тодорхой асуудлыг хөндсөн 3 зөвлөмж хүргүүлэн ажиллажээ.

Дотоод аудитор тайлант онд төсөв төлөвлөгөө, үйлдвэрлэл, хангамж, санхүү бүртгэлийн үйл ажиллагаа болон худалдан авалт, ТБЗАХ, хөрөнгө оруулалтын чиглэлээр хяналтыг гүйцэтгэж, 7 багц зөвлөмж өгч, хэрэгжилтийг нь хянаж, тайлагнасан байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьяр хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Эрчим хүчний хөгжлийн төв ТӨХК -ний гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн А/89 дугаар тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг батлуулан мөрдөж байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн боловч үйл ажиллагааны онцлогийг бүрэн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 379.1 сая төгрөгөөр буюу 1.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	4,813,676.30	8,154,996.89	3,341,320.59
Дансны авлага	1,116,704.70	1,119,715.49	3,010.79
Бусад авлага	1,522.30	9,576.79	8,054.49
Бараа материал	382,723.40	386,997.41	4,274.01
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	47,779.80	19,560.05	(28,219.75)
Үндсэн хөрөнгө	21,431,321.50	17,723,696.90	(3,707,624.60)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	**27,793,728.00**	**27,414,543.53**	**(379,184.47)**
Богино хугацаат өр төлбөр	6,115,939.40	4,268,650.49	(1,847,288.91)
Урт хугацаат өр төлбөрийн дүн	3,731,110.10	3,731,110.14	0.04
Эздийн өмчийн дүн	17,946,678.50	19,414,782.90	1,468,104.40
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	**27,793,728.00**	**27,414,543.53**	**(379,184.47)**

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 8,155.0 сая төгрөгөөс 10.3 сая төгрөг нь бэлэн мөнгө, 8,144.7 сая төгрөг нь арилжааны банкны харилцах дансанд байршиж байна.

Авлага дансны үлдэгдэлд 365.83 сая төгрөг Түмэн-Алт ХХК-тай холбоотой үүссэн авлага бөгөөд шүүхийн шийдвэртэй, 392.73 сая төгрөг 2013 онд Эрчим хүчний газраас "Эрчим хүчний хөгжлийн төв" ТӨҮГ-д балансаас балансад шилжиж ирсэн авлага, 194.3 сая төгрөг Эрчим хүчний сайдын 2022 оны 10 дугаар сарын 25-ний өдрийн А/215, А/218, А/219 тоот тушаалын дагуу эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, угсралт, засварын ажил, туршилт тохируулгын ажил үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох журмыг "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨААТҮГ байсныг "Эрчим хүчний үндэсний төв" ТӨХХК болгон өөрчилсөнтэй холбоотой шилжиж ирсэн авлага, зураг төсөл магадлалын авлага 18.9 сая төгрөг, сургалтын авлага 79.9 сая төгрөг, сэргээгдэх эрчим хүчний авлага 24.1 сая төгрөг, түрээсийн авлага 5.8 сая төгрөг нэгдсэн лабораторийн авлага 36.4 сая төгрөг, хэвлэх цехийн авлага 1.2 сая төгрөг ажилчдаас авах авлага 9.5 сая төгрөгийн тус тус бүртгэлтэй байна.

Урьдчилж төлсөн тооцоо дансанд хүлээн авсан бараа ажил үйлчилгээг үндэслэн шатахууны тооцооны үлдэгдэл 1.7 сая төгрөг, худалдаа хөгжлийн банканд тендерийн баталгаа байршуулсан 3.5 сая төгрөг Би ти солюшн ХХК-д шилжүүлсэн программын гэрээний төлбөр 13.2 сая төгрөгийн төлбөрүүд бүртгэлтэй байгаа бөгөөд оны эхнээс 28.2 сая төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын худалдан авсан 347.8 сая төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагаандаа зарцуулсан 343.6 сая төгрөг ба бараа материалын үлдэгдэл 4.3 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансанд барилга байгууламж капиталжуулах их засвартай холбоотой 160.1 сая төгрөг, тоног төхөөрөмж 228.9 сая төгрөг, тавилга эд хогшил 2.3 сая төгрөг, компьютер дагалдах хэрэгсэл 101.7 сая төгрөг, биет бус хөрөнгө 83.3 сая төгрөг шинээр худалдан авсан, Чингэлтэй дүүргийн 19-р хороонд байрших 3,756.0 сая төгрөгийн балансын үнэ бүхий 41,920.0 м2 бүхий Шадивлангийн дээд аманд байрших зуслангийн газрыг Чингэлтэй дүүргийн засаг даргын 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн А/306 тоот захирамжаар

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

газар эзэмших гэрчилгээг хүчингүй болгосон, байгууллагаас 2024 оны 4 дүгээр сарын 30-ны 1/318 тоот, 2024 оны 5 дугаар сарын 1-ны 1/322 тоот албан бичгээр Чингэлтэй дүүргийн газрын албанд гэрчилгээг сунгах хүсэлт хүргүүлсэн боловч хүлээж аваагүй тул үндсэн хөрөнгөөс хасалт хийсэн байна.

Богино хугацаат өр төлбөрийн дансны Аж ахуй нэгж байгууллагад өгөх өглөг 361.0 сая төгрөг, харьяа үйлвэрт өгөх өглөг гэрээний дагуу 44.4 сая төгрөг, үйлдвэрчний эвлэлийн суутгалын өглөг 1.7 сая төгрөг ажилчдад өгөх өглөг, 2.9 сая төгрөг, хувь хүмүүст өгөх өглөг 0.7 сая төгрөг, урьдчилж олсон орлогод сургалт үйлдвэрлэлийн төв 25.9 сая төгрөг, нэгдсэн лаборатори 10.3 сая төгрөг, зураг төсөл магадлал 5.1 сая төгрөг, техник хяналт 1,649.2 сая төгрөг, сэргээгдэх эрчим хүч 25.3 сая, тусгай зөвшөөрөл 961.7 сая төгрөг, Татварын өглөг 1,166.2 сая төгрөг, НДШ-н өглөг 9.1 сая төгрөг тус тус бүртгэлтэй байна

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ-ын санхүүгийн тайланд бүртгэлтэй байсан, компанийг өөрчлөн байгуулах шийдвэрээр шилжиж ирсэн 1992 оны Эгийн голын усан цахилгаан станц барих төслийн хүрээнд 1152-MON(SF) дугаар гэрээгээр гүйцэтгүүлсэн 3,731.1 сая төгрөгийн ТЭЗҮ, зураг төслийн судалгааны өр төлбөр байна. Урт хугацаат өрийг "Эгийн голын усан цахилгаан станц" ТӨХК-д шилжүүлэх асуудлаар эрх бүхий байгууллагуудад албан бичгээр хандсан боловч шийдэгдээгүй байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК нь үйлдвэрлэл болон санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2024 оны техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин Эрчим хүчний сайдын 2024 оны 01 дүгээр сарын 03-ний А/08 тушаалаар 9,707.2 сая төгрөгийн орлоготой 9,073.1 сая төгрөгийн зардалтай 634.1 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар батлагдсан ба төсвийн жилийн явцад Эрчим хүчний сайдын 2024 оны 6 дугаар сарын 26-ний өдөр А/142 дугаар тушаалаар 11,736.1 сая төгрөгийн орлоготой 11,426.6 сая төгрөгийн зардалтай 309.5 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай 2,138.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай ажиллахаар тодотгол оруулан батлагдсан байна.

Тайлант онд 13,142.7 сая төгрөгийн орлоготой 7,368.5 сая төгрөгийн зардалтай 633.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай ажилласан байна.

Нийт орлогын төлөвлөгөөг 11,736.1 сая төгрөгөөр төлөвлөснөөс 13,142.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, орлого 1,406.6 сая төгрөгөөр буюу 12 хувиар давж биелүүлсэн байна. Эрдэнэбүрэнгийн УЦС төсөл хэрэгжих эхлээгүйтэй холбоотой сэргээгдэх эрчим хүчний орлого 2,028.9 сая төгрөг тасалдсан боловч бусад орлого 3,458.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь орлогын үзүүлэлтэд нөлөөлжээ.

Нийт зардлыг 11,426.6 сая төгрөгөөр төлөвлөснөөс 2024 онд 7,368.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, 4,058.1 сая төгрөг буюу 36 хувиар хэмнэлттэй ажилласан нь цалингийн зардал 1,012.9 сая төгрөг, албан татвар төлбөр хураамжийн зардал 1,012.9 сая төгрөг, судалгаа хөгжүүлэлтийн зардал 406.6 сая төгрөг болон Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц хэрэгжиж эхлээгүйтэй холбоотой төсөлтэй холбогдож гарах байсан 646.0 сая төгрөгийн зардал гараагүйтэй холбоотойгоор хэмнэлт үүссэн байна.

Компани 2024 онд Эрчим хүчний сайдын А/142 дугаар тушаалаар их засвар техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлыг 2,138.8 сая төгрөгөөр төлөвлөснөөс автомашин 2 ширхэг, Сургалт үйлдвэрлэлийн төвийн их засварыг худалдан авах ажиллагааны журмын дагуу тендер зарласан боловч санал болгосон үнийн дүн бага гэсэн шалтгаанаар оролцогч орж ирээгүй худалдан авалт хийгдээгүй, мөн Эрдэнэбүрэнгийн УЦС хэрэгжиж эхлээгүйтэй холбоотой 980.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хойшлогдсон.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, найдваргүй болон эзэн холбогдогч тодорхойгүй олон жил болсон авлагуудыг холбогдох эрх бүхий дээд шатны байгууллагаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, худалдан авах ажиллагааны холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж шалгаруулах, НББББББ-ийг шинэчлэгдсэн стандарт, хууль, дүрэм, журамд нийцүүлэн өөрчлөлтийг өөрсдийн нөөц бололцоогоороо сайжруулалт хийх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Мэдээлэл-Аудит ХХК-ийн аудитор Д.Туяа, Ц.Отгонжаргал, Н.Пүрэвсүрэн, С.Адьяахүү нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер А.Гэрэлмаа, захирал Д.Товуудорж нар анхан шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитор Г. Оюунтөгөлдөр, аудитын менежер Б. Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц. Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Эрчим хүчний үндэсний төв ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газар болон Мэдээлэл-Аудит ХХК-д 2025 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн 01/95 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогийн дэлгэрэнгүй тайлан, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны нийт зардлын 7,242.5 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцож, 108.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2024 онд 14 орон тоо дутуу ажиллаж, 968.4 сая төгрөгийн бодит хэмнэлт гаргасан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАГДМАЛ ТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих орлогын 10,012,849.2 мянган төгрөгийн 460 мэдээ, зарлагын 3,290,100.2 мянган төгрөгийн 138 мэдээ, нийт 149 мэдээллээс 149 мэдээллийг хугацаанд нь 100 хувийн биелэлттэй байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн А/89 тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба шинэчлэгдсэн стандарт, хууль, дүрэм, журамд нийцүүлэн өөрчлөлтийг тухай бүрд нь тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Ерөнхий нягтлан бодогчийн эрх үүрэг 20.2.2. "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББББББ-ийг шинэчлэгдсэн стандарт, хууль, дүрэм, журамд нийцүүлэн өөрчлөлтийг өөрсдийн нөөц бололцоогоор сайжруулалт хийх.

2. Зорилтот түвшинд тусгагдаагүй 2 төрлийн ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оруулан худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.3 "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зорилтот түвшинд тусгасан ажил, бараа, үйлчилгээг худалдан авалтын төлөвлөгөөнд тусгаагүй, хууль, дүрэм, журамд нийцүүлэн худалдан авалтыг зохион байгуулаагүй, зөрчлийг давтан гаргуулахгүй байхаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

3. ЭХҮТ/20240203029 дугаартай тендерийг зарласан боловч шаардлагатай тендерийн бичиг баримт /ажлын даалгавар/-ыг оруулаагүй, тендерийн ерөнхий шаардлага хангаагүй байгууллага шалгаруулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1 Дараах нөхцөлийн аль нэг үүссэн бол оролцогчийг ерөнхий шаардлага хангаагүй гэж үзнэ. "7.1.2 Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл татварын , эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг зарлахдаа тендерийн бичиг баримтыг иж бүрэн оруулаагүй, тендерийн шаардлага хангасан оролцогч байгууллагыг шалгаруулаагүй, зөрчлийг давтан гаргуулахгүй байхаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 466.7 сая төгрөгийн асуудлыг илрүүлж, асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад алдааг залруулж, зөрчлийг арилгагаагүй байгаад албан шаардлага, зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 5.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 392.7 сая төгрөгийн 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгснийг хянахад хэрэгжилт 75 хувийн биелэлттэй байна

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо		
Б	1	2	3	4	5	6
1	Төлбөрийн акт	1	5,916.0	1	5,916.0	100%
2	Албан шаардлага	1	392,733.6	1		0
3	Зөвлөмж	2	-	1		100%
	Нийт дүн	**4**	**398,649.6**	**4**	**5,916.0**	75%

Өмнөх аудитын зөвлөмжөөр өгөгдсөн 5.9 сая төгрөгийн төлбөрийн актыг төлж барагдуулсан, олон жилийн насжилттай авлагыг удирдах дээд шатны байгууллагад хүргүүлсэн боловч шийдэгдээгүй тооцоо нийлж баталгаажуулаагүй авлагын үлдэгдлээс 392.7 сая төгрөгийн авлага байна. Хэрэгжих шатандаа байгаа 392.7 сая төгрөгийн авлагын тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг аудитын илрүүлэлт хэсэгт тусгаж, албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал гараагүй болно.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАГДМАЛ ТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 7,215,528.2 мянган төгрөгийн алдаа[1] илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл банкны үлдэгдлийн баталгаатай 24.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь санхүүгийн тайлагналын "тохиолдсон байх" батламж мэдэгдлийг;
- Өмчийн өөрчлөлтийн тайланд өмчид гарсан өөрчлөлтийг 3,756,032.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь санхүүгийн тайлагналын "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг;
- Тээврийн хэрэгсэлийн элэгдэлийг 948.4 мянган төгрөгөөр илүү байгуулж, дансны үлдэгдлийг сөрөг утгаар тайлагнасан нь санхүүгийн тайлагналын "оршин байх" батламж мэдэгдлийг;
- ТБЕА энержи монголиа ХХК-д төлөх 3,458,523.9 мянган төгрөгийн өр төлбөр нотлогдохгүй байгаа бөгөөд төлөх үүрэг байхгүй байгаа нь санхүүгийн тайлагналын "үнэлгээ ба хуваарилалт", "тохиолдсон байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 557.5 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс 542.5 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, 15.0 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 542.5 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.2 Албан шаардлага

1. 2024 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн №ЭХЧТ/41/2024 дугаар "Туулах чадвар сайтай автомашинаар үйлчилгээ үзүүлэх, төлбөр тооцоо барагдуулах гэрээ"-г байгуулж, өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй, худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй үйлчилгээнд 28,400.0 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11.2 "Төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1."зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

> <u>Шийдвэрлэсэн нь</u>: Өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй хөрөнгө зарцуулсан, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

2. Майнримек ХХК, Блейк стар альфа ХХК, Огмент ХХК, Визлис визард ХХК, Энхансмент ХХК-уудтай байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контентийн үйлчилгээ авах гэрээг байгуулж, өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй, худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй үйлчилгээнд 99,800.0 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсан нь "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11.2 "Төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах", Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийн 10.3.Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй хөрөнгө зарцуулсан, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

3. Тосны усыг тодорхойлох багаж, Тосны зунгааралт тодорхойлох багаж гэсэн ижил төрлийн бүтээгдэхүүнийг нэг байгууллагаас 21,600.00 мянган төгрөгөөр худалдан авсан нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.3.Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил,үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар Бараа, ажил,үйлчилгээ 20.0 сая төгрөг" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ижил төрлийн бүтээгдэхүүнийг багцлан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оруулан харьцуулалтын арга ашиглаагүй худалдан авалт хийсэн, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

4. Байгууллагаас авах 392.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан " Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тайланд онд шатахууны жолоочийн замын хуудас байхгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байгаа нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаарх Жишиг норм батлах тухай" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж

Шатахууны жолоочийн замын хуудастай болох, анхан шатны баримтын иж бүрдэл хангах

Үндсэн хөрөнгө данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Тус төв нь 2024 оны жилийн эцсийн байдлаар 890 нэр төрлийн 3,722.8 сая төгрөгийн хөрөнгө элэгдлээрээ өртгөө бүрэн нөхөж ашиглалтын хугацаа дууссан байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ХЯЗГААРЛАГДМАЛ САНАЛ ДҮГНЭЛТ

нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж

Эрх бүхий байгууллагад хандаж хүсэлт гаргаж асуудлыг шийдвэрлэх.

Дээрх аудитын шийдвэрийн хэрэгжилтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл банкны үлдэгдлийн баталгаатай 24.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	24.0					1	24.0				
Өмчийн өөрчлөлтийн тайланд өмчид гарсан өөрчлөлтийг 3,756,032.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	3,756,032.0					1	3,756,032.0				
Тээврийн хэрэгсэлийн элэгдэлийг 948.4 мянган төгрөгөөр илүү байгуулж, дансны үлдэгдлийг сөрөг утгаар тайлагнасан	1	948.4					1	948.4				
ТБЕА энержи монголиа ХХК-д төлөх 3,458,523.9 мянган төгрөгийн өр төлбөр нотлогдохгүй байгаа бөгөөд төлөх үүрэг байхгүй байна	1	3,458,523.9					1	3,458,523.9				
Дүн	**4**	**7,215,528.2**					**4**	**7,215,528.2**				

ХЯЗГААРЛАЛТАЙ
Санхүүгийн аудитын бүгдэлгэ
СНАГ ДАГНЭЛТ

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Тайланд онд шатахууны жолоочийн замын хуудас байхгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.	1	-					1	-				
2	2024 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн №ЭХЧТ/41/2024 дугаар "Туулах чадвар сайтай автомашинаар үйлчилгээ үзүүлэх, төлбөр тооцоо барагдуулах гэрээ"-г байгуулж, өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй, худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй үйлчилгээнд 28,400.0 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсан	1	28,400.0			1	28,400.0						
3	Майнримек ХХК, Блейк стар альфа ХХК, Огмент ХХК, Визлис визард ХХК, Энхансмент ХХК-уудтай байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контентийн үйлчилгээ авах гэрээг байгуулж, өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй, худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй үйлчилгээнд 99,800.0 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсан	1	99,800.0			1	99,800.0						

4	Тосны усыг тодорхойлох багаж, Тосны зунгааралт тодорхойлох багаж гэсэн ижил төрлийн бүтээгдэхүүнийг нэг байгууллагаас 21,600.00 мянган төгрөгөөр худалдан авсан	1	21,600.0			1	21,600.0						
5	Байгууллагаас авах 392.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй	1	392,733.6			1	392,733.6						
6	Тус төв нь 2024 оны жилийн эцсийн байдлаар 890 нэр төрлийн 3,722.8 сая төгрөгийн хөрөнгө элэгдлээрээ өртгөө бүрэн нөхөж ашиглалтын хугацаа дууссан байна	1						1					
	Дүн	**6**	**542,533.6**			**4**	**542,533.6**	**2**					

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Бусад хууль тогтоожийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн А/89 тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба шинэчлэгдсэн стандарт, хууль, дүрэм, журамд нийцүүлэн өөрчлөлтийг тухай бүрд нь тусгаагүй байна.	1	15,000.0					1	15,000.0
Зорилтот түвшинд тусгагдаагүй 2 төрлийн ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оруулан худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.	1				1			
ЭХҮТ/20240203029 дугаартай тендерийг зарласан боловч шаардлагатай тендерийн бичиг баримт /ажлын даалгавар/-ыг оруулаагүй, тендерийн ерөнхий шаардлага хангаагүй байгууллага шалгаруулсан.	1				1			
Нийт дүн	**3**	**15,000.0**			**2**		**1**	**15,000.0**

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр Дугаар 586/А0150082 Улаанбаатар хот
СНТГ-2025/5/ХА- СТА-ТЕЧГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ЭХҮТ/20240203029 дугаар тендерийг зарласан боловч шаардлагатай тендерийн бичиг баримт /ажлын даалгавар/-ыг оруулаагүй, тендерийн ерөнхий шаардлага хангаагүй байгууллагыг сонгон шалгаруулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Дараах нөхцөлийн аль нэг үүссэн бол оролцогчийг ерөнхий шаардлага хангаагүй гэж үзнэ", 7.1.2-т "Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл татварын , эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй, 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг зарлахдаа тендерийн бичиг баримтыг иж бүрэн оруулаагүй, тендерийн шаардлага хангасан байгууллагыг сонгон шалгаруулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Д. Бямбасүрэн/, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч /Б. Амараа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР — Б. ДОЛГОРСҮРЭН
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ — Д.ТОВУУДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

АТА9693 9023030583

Z:\Alban Shaardlaga\2025\0314 SNAG-33.Docx

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр Дугаар 585/ДОХ0002 Улаанбаатар хот

СНАГ-2025/5/НА-СТА-ТОЧГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зорилтот түвшинд тусгаагүй "Санхүүгийн дүгнэлт гаргуулах", "Харуул хамгаалалтын ажил үйлчилгээ"-нд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-т "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зорилтот түвшинд тусгаагүй ажил үйлчилгээг зохион байгуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Д. Бямбасүрэн/, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч /Б. Амараа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Б. ДОЛГОРСҮРЭН
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Д.ТОВУУДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9023030583

Z:\Alban Shaardlaga\2025\0314 SNAG-33.Docx

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр Дугаар 584/А0150092 Улаанбаатар хот
СанБГ-2025/5/нА-СТА-Тамг

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тосны ус болон тосны зунгааралт тодорхойлох 21,600,000.00 (Хорин нэгэн сая зургаан зуун мянган) төгрөгийн ижил төрлийн багажийг шууд худалдан авалт хийх зорилгоор баталсан төсвийг хуваж, нэг байгууллагаас худалдан авсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хуваж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Худалдан авах ажиллагаанд баримтлах шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар, бараа, ажил,үйлчилгээ 20.0 сая төгрөг" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шууд худалдан авалт хийх зорилгоор батлагдсан төсвийг хуваж, нэг байгууллагаас худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Д. Бямбасүрэн/, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч /Б. Амараа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Б. ДОЛГОРСҮРЭН
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Д.ТОВУУДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

АТА9493 90 0109
9023030533

Z:\Alban Shaardlaga\2025\0314 SNAG-33.Docx

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр Дугаар 583/А0150092 Улаанбаатар хот
СНТТ-2025/5/ЖА-СТА-ТОЧГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Майнримек ХХК, Блейк стар альфа ХХК, Огмент ХХК, Визлис визард ХХК, Энхансмент ХХК-тай нэвтрүүлэг, контентын үйлчилгээ авах гэрээг байгуулж, өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 99,800,000.00 (Ерэн есөн сая найман зуун мянган) төгрөгийн үйлчилгээг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т "Төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай 44 дүгээр 44.1.Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хуваах худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан", 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй үйлчилгээг дахин санхүүжүүлэхгүй байх, зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Д. Бямбасүрэн/, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч /Б. Амараа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Б. ДОЛГОРСҮРЭН
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Д.ТОВУУДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2025\0314 SNAG-33.Docx

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр Дугаар 582/А0150082 Улаанбаатар хот

Сноот- 2025/5/НА-СТА- ТОЧГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Туулах чадвар сайтай автомашинаар үйлчилгээ үзүүлэх, төлбөр тооцоо барагдуулах" ЭХЧТ/41/2024 дугаар гэрээг 2024 оны 5 дугаар сарын 02-ны өдөр байгуулж, өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй, худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй үйлчилгээнд 28,400,000.00 (Хорин найман сая дөрвөн зуун мянган) төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай 44 дүгээр 44.1."Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д "Зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан", 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй арга хэмжээг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Д. Бямбасүрэн/, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч /Б. Амараа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Б. ДОЛГОРСҮРЭН
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Д.ТОВУУДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

АТА9693 9023030583

Z:\Alban Shaardlaga\2025\0314 SNAG-33.Docx

Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160, Монгол Улс